



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 3 сарын 30 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Компанийн 2017 оны санхүүгийн
тайлан батлах, Төлөөлөн удирдах зөвлөлийг
шинэчлэн батлах тухай

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, 20 дугаар зүйлийн 20.1, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 75 дугаар зүйлийн 75.4 дэх заалт, 77, 79 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн "Журам батлах тухай" 80 дугаар тогтоол, Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөө аж ахуйн давхар даатгал" хаалттай хувьцаат компанийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хавсралт ёсоор баталсугай.

2. "Хөдөө аж ахуйн давхар даатгал" хаалттай хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

ТУЗ-ийн дарга:
С.Наранцогт

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:
Н.Дэлгэрбат

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах, зээл даатгалын хэлтсийн мэргэжилтэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Ц.Болорчулуун

Үндэсний статистикийн хорооны Статистикийн эрдэм шинжилгээ, арга зүйн газрын дарга

А.Дэмбэрэл

Монголын даатгалын холбооны удирдах зөвлөлийн дарга

П.Эрдэнэбаатар

"Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо"-ны Удирдах зөвлөлийн гишүүн

Д.Насанжаргал

Хараат бус


Б.Шаравсамбуу

Хараат бус

Ц.Түмэнхишиг

3. Энэ тушаалын нэгдүгээр заалтаар батлагдсан санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажиллахыг компанийн гүйцэтгэх захирал /Г.Энхтайван/-д, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус нэг гишүүнийг сонгон шалгаруулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Наранцогт/-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн 1 дүгээр тоот тушаалын 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

0 344